

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны .... дугаар сарын  
....-ний өдөр

Улаанбаатар хот

### СОЁЛЫН ТУХАЙ

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

#### НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

##### **1 дүгээр зүйл.Хуулийн зорилт**

1.1.Энэ хуулийн зорилт нь төрөөс соёлын талаар баримтлах бодлого, зарчмыг тодорхойлж, соёлын үйл ажиллагаа эрхлэх, түүний удирдлага, зохион байгуулалт, оролцогчдын үүрэг, эрх, эдийн засгийн үндсийг тогтоохтой холбогдон үүсэх нийтлэг харилцааг зохицуулахад оршино.

##### **2 дугаар зүйл.Соёлын тухай хууль тогтоомж**

2.1.Соёлын хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, энэ хууль, болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

##### **3 дугаар зүйл.Хуулийн нэр томьёо**

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“соёлын үнэт зүйл” /элемент/ гэж хүний оюун санаа, үйлдэхийн арга ажиллагаагаар бий болсон соёлын агуулга бүхий биет болон биет бус илэрхийллийн төрлүүдийг;

3.1.2.“соёлын үйл ажиллагаа” гэж соёлын үнэт зүйлийг бүтээн туурвих, судлан хөгжүүлэх, үйлдвэрлэх, түгээх, хэрэглэхэд чиглэсэн үйл ажиллагааг;

3.1.3.“соёлын байгууллага” гэж энэ хуульд заасан журмын дагуу соёлын үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээдийг;

3.1.4.“соёлын ажилтан” гэж соёлын үйл ажиллагааг дагнан буюу хамтран эрхэлж байгаа иргэн, хамт олон, бүлэг хүнийг;

3.1.5.“соёлын бүтээгдэхүүн” гэж соёлын үнэт зүйл, түүнтэй холбоотой үйлчилгээг агуулсан эдийн засгийн нэмүү өртөг шингэсэн биет болон биет бус зүйлийг;

3.1.6.“соёлын үйлдвэрлэл” гэж эдийн засгийн үр ашгийг нь харгалзан төрөөс тогтоосон чиглэлээр техник технологи, инноваци, зохиогчийн эрхэд суурилсан соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээг төлөвлөх, хөгжүүлэх, үйлдвэрлэх, түгээх, хэрэглэхтэй холбоотой үйлдвэрлэлийг;

3.1.7.“уран сайхан, нийтлэл, танин мэдэхүйн нэвтрүүлэг” гэж уран сайхны кино, төле жүжиг, телевизийн олон ангит кино, хөгжөөнт хөтөлбөр, тоглолт, баримтат болон хүүхэлдэйн кино, газар зүй, түүх, соёл, зан заншил, хэл зохиол, зан үйл, соёлын өвийг тайлбарлан таниулсан аливаа бүтээл ба сэтгүүл зүйн бусад төрөл жанрын бүтээлийг;

3.1.8.“үндэсний нэвтрүүлэг” гэж телевиз, радио, кабелийн сувгаар дамжуулж байгаа тухайн нэвтрүүлгийн зохиолч, ерөнхий найруулагч, продюсерийн аль нэг нь Монгол Улсын иргэн байх, эсхүл зураг авалт, дуу бичлэг, сурвалжлах багийн бүрэлдэхүүний гуравны нэгээс доошгүй хувь нь Монгол Улсын иргэн байх бүх төрлийн бүтээлийг;

3.1.9.“соёлын агент” гэж соёлын ажилтанг олон улсын түвшинд соёлын үйл ажиллагаанд оролцуулах, санал болгох, түүний ашиг сонирхолыг төлөөлөн хэлцэх хийх этгээдтэй холбож өгөх, менежметийн үүрэг гүйцэтгэх үйл ажиллагааг зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийг;

#### **4 дүгээр зүйл. Соёлын үйл ажиллагаанд баримтлах үндсэн зарчим**

4.1. Соёлын үйл ажиллагаанд дараах үндсэн зарчим баримтална:

4.1.1.үндэсний соёл, уламжлалыг эрхэмлэх, хөгжүүлэх, нандигнан өвлөх;

4.1.2.соёлын үнэт зүйлд хүндэтгэлтэй хандах;

4.1.3.соёлын үйл ажиллагааны чиглэл, хэлбэрийг чөлөөтэй сонгох, хөгжүүлэх;

4.1.4.соёлын боловсрол олгох үйл ажиллагааг дэмжих, иргэдийг соён гэгээрүүлэх;

4.1.5.соёлын үйл ажиллагаа эрхлэгчдэд тэгш, нээлттэй, ил тод хандах;

4.1.6.соёлын үнэт зүйлийн үнэлэмжийг нэмэгдүүлэх, соёлын байгууллагын бие даасан, санхүүгийн тогтвортой байдлыг хангах.

### **ХОЁРДУГААР БҮЛЭГ**

#### **СОЁЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, БАЙГУУЛЛАГА**

#### **5 дугаар зүйл. Соёлын үйл ажиллагаа**

5.1. Соёлын үйл ажиллагааг дараах чиглэлээр явуулна:

5.1.1.соёлын өвийг ашиглах, судлах, хамгаалахтай холбоотой үйл ажиллагаа;

5.1.2.номын сангийн үйлчилгээтэй холбоотой үйл ажиллагаа;

5.1.3.ном, утга зохиолын бүтээл туурвих, түгээхтэй холбоотой үйл ажиллагаа;

5.1.4.хөгжмийн урлагийн бүтээл туурвих, үйлдвэрлэх, түгээхтэй холбоотой үйл ажиллагаа,

5.1.5.тайзны урлагийн бүтээл туурвих, тоглох, түгээхтэй холбоотой үйл ажиллагаа,

5.1.6.визуал урлаг, дүрслэх урлаг, уран сайхны гэрэл зураг, гар урал, хэрэглээний урлагийн бүтээл туурвих, түгээхтэй холбоотой үйл ажиллагаа;

5.1.7.кино урлаг, дуу-дүрсний уран бүтээл туурвиштай холбоотой үйл ажиллагаа;

5.1.8.соёл, урлагийн арга хэмжээ, тоглолт, наадам зохион байгуулахтай холбоотой үйл ажиллагаа;

5.1.9.соёлын боловсрол олгохтой холбоотой үйл ажиллагаа;

5.1.10.соёл судлал, эрдэм шинжилгээ, судалгааны үйл ажиллагаа.

5.2.Соёлын өвийг хамгаалахтай холбоотой харилцааг Соёлын өвийг хамгаалах тухай хуулиар нарийвчлан зохицуулна.

5.3.Номын сангийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг Номын сангийн тухай хуулиар нарийвчлан зохицуулна.

5.4.Кино урлагтай холбоотой харилцааг Кино урлагийг дэмжих тухай хуулиар нарийвчлан зохицуулна.

5.5.Музейн үйл ажиллагаатай холбоотой харилцааг Музейн тухай хуулиар нарийвчлан зохицуулна.

## **6 дугаар зүйл.Соёлын үйл ажиллагаанд оролцох, эрхлэх**

6.1.Иргэн нь хуулиар хориглосноос бусад нөхцөлд соёлын үйл ажиллагаанд чөлөөтэй оролцож, соёлын үйл ажиллагааг эрхэлнэ.

6.2.Соёлын үйл ажиллагаа эрхлэх байгууллагыг энэ хууль холбогдох бусад хуульд заасны дагуу өмчийн аль ч хэлбэрт үндэслэн үүсгэн байгуулж болно.

6.3.Соёлын үйл ажиллагаа эрхлэгч нь жил бүр үйл ажиллагааны чиглэл, статистик мэдээллийг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргаж өгнө.

6.4 Соёлын үйл ажиллагаа эрхэлдгээс бусад аж ахуйн нэгж, байгууллага нь соёлын үйл ажиллагааг дэмжих, үнэт зүйлсийг хадгалж хамгаалах, сурталчлах, ажилтны авьяасыг хөгжүүлэх, соёл, урлагийн үйлчилгээнд хамрагдахад дэмжлэг үзүүлнэ.

## **7 дүгээр зүйл. Соёлын байгууллага, чиг үүрэг, удирдлага**

7.1.Соёлын байгууллагын төрөл, үйлчилгээ, үйл ажиллагааны чиглэл, хамрах хүрээг үүсгэн байгуулагч тогтооно.

7.2. Соёлын байгууллагыг Иргэний хууль, Хуулийн этгээдийн бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон холбогдох бусад хуульд заасны дагуу байгуулна.

7.3. Соёлын үнэт зүйлийг хадгалах, хөгжүүлэх, үндэсний хэмжээнд үзүүлэх үйлчилгээ, нийгмийн хөгжил, соён гэгээрүүлэх үйл хэрэгт оруулах хувь нэмэр, эрхэлж буй соёлын үйл ажиллагааны чиглэлээр Монгол Улсыг төлөөлөх үүргийг хэрэгжүүлэх чадавх, нөхцөлийг харгалзан төрийн өмчийн соёлын байгууллагыг үндэсний соёлын байгууллагад тооцож болно.

7.4. Үндэсний соёлын байгууллага нь өөрийн эрхэлж буй үйл ажиллагааны чиг үүргийг улсын хэмжээнд нэгтгэн зохион байгуулах, өмчийн хэлбэр харгалзахгүй соёлын байгууллагад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, харилцан уялдааг хангах, уран бүтээлийн нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх, мэргэшсэн байгууллага байна.

7.5. Үндэсний соёлын байгууллага нь харьяандыа судалгааны нэгж, лаборатори ажиллуулж болно.

7.6. Үндэсний соёлын байгууллагад тооцоход тавигдах шалгуур үзүүлэлт тогтоох, цуцлах шийдвэрийг Засгийн газар гаргана.

7.7. Гадаад улсад монголын соёлын төв байгуулах, Монгол Улсад гадаадын улсын соёлын төв байгуулах асуудлыг Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хүрээнд шийдвэрлэнэ.

7.8. Соёлын байгууллага дараахь нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ:

7.8.1. соёлын үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд мэргэжлийн ур чадвар, үйлчилгээний өндөр түвшинд явуулах;

7.8.2. зориулалтын барилга байгууламж, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл нь эрүүл ахуйн болон стандартын шаардлага хангасан, соёлын ажилтны хөдөлмөрийн онцлогт тохирсон, аюулгүй ажиллагааны нөхцөлийг бүрдүүлсэн байх;

7.8.3. үйлчилгээний стандарт мөрдөн ажиллах;

7.8.4. соёлын ажилтны мэргэжил дээшлүүлэх, давтан сургах, нийгмийн баталгааг нь хангах.

7.9. Төрийн өмчийн соёлын байгууллагын удирдлагыг соёлын асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн, орон нутгийн соёлын байгууллагын удирдлагыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн аймаг, нийслэлийн Засаг дарга томилж, чөлөөлнө.

7.10. Энэ хуулийн 7.9-д зааснаас бусад соёлын байгууллагын удирдлагыг үүсгэн байгуулагч томилж, чөлөөлнө.

## 8 дугаар зүйл. Соёлын ажилтан түүний эрх, үүрэг

8.1. Соёлын үйл ажиллагааны чиглэлээр мэргэжил эзэмшсэн, мэргэшсэн соёлын ажилтанд мэргэшлийн зэрэг олгоно. Мэргэшлийн зэрэг олгох журмыг Засгийн газар батална.

8.2. Соёлын ажилтан дараахь эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

8.2.1. хууль тогтоомжийн хүрээнд соёлын үйл ажиллагаа явуулах нөхцөл бололцоогоор хангуулах;

8.2.2. судалгаа шинжилгээний ажил хийх;

8.2.3. мэдлэг боловсрол, чадвараа бие даан болон байгууллагын дэмжлэгтэй дээшлүүлэх;

8.2.4. соёлын үйлчилгээг иргэнд мэргэжлийн түвшинд, чанартай хүргэх;

8.2.5. соёл, урлагийн ажилтны ёс зүйн дүрмийг чанд мөрдөх;

8.2.6. үндэсний уламжлалт соёл, соёлын өвийг хадгалж хамгаалах, өвлөн уламжлуулахад идэвх санаачилгатай ажиллах;

8.2.7. эрхэлж буй чиг үүргийн дагуу соёлын үйлчилгээг иргэдийг соён гэгээрүүлэх, төлөвшүүлэхэд чиглүүлэх.

## **9 дүгээр зүйл. Соёл судлал**

9.1. Соёлын салбарын хөгжлийн стратеги, төлөвлөлт, бодлогын суурь судалгаа хийх, судалгааны мэдээллээр хангах, мэдээлэл, судалгааны байгууллагыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд ажиллуулна.

9.2. Соёл судлалын байгууллагын дүрэм, бүтцийг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

9.3. Соёл судлал, салбарын төлөв байдлын дүн шинжилгээ, мэдээлэлд үндэслэн соёлын төлөв байдлын тайланг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь 2 жил тутам Засгийн газарт танилцуулна.

## **10 дугаар зүйл. Соёлын боловсрол**

10.1. Соёлын боловсрол нь иргэнийг соён гэгээрүүлэх, эх орон ч сэтгэлгээг төлөвшүүлэх, соёлын үнэт зүйлийг хайлран хамгаалах сэтгэхүйг хөгжүүлэхэд чиглэгдэнэ.

10.2. Соёлын боловсрол олгох чиглэлээрх үндэсний хөтөлбөрийг Засгийн газар батална.

10.3. Боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад соёлын үйл ажиллагааны зарим чиглэлээр мэдлэг олгох заавал судлах уран бүтээлийн жагсаалтыг боловсролын болон соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

10.4. Музейн үйлчилгээнд 16 хүртэлх насны хүүхэд үнэ төлбөргүй хамрагдана. Музейн үйлчилгээнд үнэ төлбөргүй хамруулахад дэмжлэг үзүүлэх журмыг Засгийн газар батална.

10.5.Орон нутгийн номын сан, орон нутаг судлах танхимын мэдээллийн үйлчилгээ нь 16 хүртэлх насны хүүхдэд үнэ төлбөргүй байна.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ**

### **СОЁЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХЭРЭГЖҮҮЛЭХ БҮРЭН ЭРХ**

#### **11 дүгээр зүйл. Соёлын үйл ажиллагааны удирдлагын тогтолцоо**

11.1.Соёлын үйл ажиллагааны удирдлагын тогтолцоо нь Засгийн газар, Соёлын үндэсний зөвлөл, соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллага, соёлын байгууллагын удирдлагаас бүрдэнэ.

#### **12 дугаар зүйл. Монгол Улсын Засгийн газрын бүрэн эрх**

12.1.Монгол Улсын Засгийн газар соёлын үйл ажиллагааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

12.1.1.төрөөс соёлын талаар баримтлах бодлогыг батлах;

12.1.2.соёлын цогцолбор байгуулж, хөгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах;

12.1.3.хүүхдийн соёл, урлагийн цогцолбор байгуулах, хүүхдэд зориулсан уран бүтээлийг дэмжих;

12.1.4.соёлын үйл ажиллагааны чиглэлээр үндэсний хөтөлбөр батлах;

12.1.5.үндэсний бахархлыг тодорхойлох, тогтоох;

12.1.6.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

#### **13 дугаар зүйл. Соёлын үндэсний зөвлөлийн чиг үүрэг**

13.1.Соёлын салбарын хөгжил, бодлого, төлөвлөлтөд санал, үнэлэлт өгөх, салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах чиг үүрэг үүрэг бүхий орон тооны бус Соёлын үндэсний зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/-тэй байна.

13.2.Зөвлөлийг Монгол Улсын Ерөнхий сайд тэргүүлнэ. Зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг Засгийн газар батална.

13.3.Зөвлөлийн ажлын албаны үүргийг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.

13.4.Соёлын үндэсний зөвлөл нь соёлын дэд зөвлөлтэй байна. Дэд зөвлөл нь бүх шатны Засаг даргын дэргэд ажиллана.

13.5.Дэд зөвлөлийн үйл ажиллагааны үлгэрчилсэн дүрмийн Соёлын үндэсний зөвлөлтэй зөвшилцөн соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

## **14 дүгээр зүйл. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх**

14.1. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага соёлын үйл ажиллагааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

14.1.1.соёлын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангуулах;

14.1.2.хууль тогтоомжоор олгосон бүрэн эрхийн хүрээнд соёлын үйл ажиллагааг зохицуулах дүрэм, журмыг баталж, хэрэгжүүлэх;

14.1.3.соёлын үйл ажиллагааны чиглэлээр захиалгат судалгаа, шинжилгээ хийлгүүлэх, инноваци, арга технологийг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх,

14.1.4.соёлын статистик мэдээллийг нэгтгэн гаргаж, соёлын удирдлага, мэдээллийн нэгдсэн сан байгуулах;

14.1.5.соёлын үйлчилгээ үзүүлэх байгууллагын барилга байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, үйлчилгээний орчны шаардлагыг боловсруулж, батлуулах;

14.1.6.соёлын ажилтны ёс зүйн дүрэм батлах;

14.1.7.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

## **15 дугаар зүйл. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх**

15.1. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага соёлын үйл ажиллагааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

15.1.1.төрөөс соёлын талаар баримтлах бодлого, соёлын хууль тогтоомж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

15.1.2.соёл, урлагийн мэргэжлийн холбоод, олон нийтийн байгууллага, хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллах, тэдгээрт дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

15.1.3.соёлын салбарын хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх, давтан сургах, мэргэшүүлэх, мэргэшлийн зэрэг олгох;

15.1.4.соёлын салбарт хэрэгжих төсөл, хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах;

15.1.5.соёлын гадаад сурталчилгаа, түгээн дэлгэрүүлэлтийн үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах;

15.1.6.соёлын үйл ажиллагааны удирдлага, мэдээллийн санг хөтлөх, хөгжүүлэх;

15.1.7.хуульд заасан бусад бүрэн эрх.

## **16 дугаар зүйл. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын бүрэн эрх**

16.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

16.1.1.харьялах нутаг дэвсгэрийн хүн амд соёлын боловсрол олгох, орон нутгийн онцлог бүхий соёлын бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих хөтөлбөр, шийдвэр баталж, хэрэгжилтийг хангуулах;

16.1.2.соёлын асуудлаар Засаг даргын тайлан мэдээллийг хэлэлцэх, санал, дүгнэлт гаргах;

16.1.3.орон нутгийн өмчийн соёлын байгууллага байгуулах, үйл ажиллагааны төсвийг баталж, мэргэжлийн түвшинд уран бүтээл туурвиход бүх талын дэмжлэг үзүүлэх.

16.3.Бүх шатны Засаг дарга нь дараахь бүрэн эрхтэй:

16.3.1.орон нутгийн онцлог бүхий соёлын бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, брэнд бий болгох, баяжуулан хөгжүүлэх, сурталчлах ажлыг зохион байгуулах:

16.3.2.орон нутгийн өмчийн соёлын байгууллагын хүний нөөцийг хөгжүүлэх, барилга байгууламжийн ашиглалтыг сайжруулах.

16.4.Аймаг, нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд соёлын газар ажиллана.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ**

### **СОЁЛЫН ЭДИЙН ЗАСАГ, ҮЙЛДВЭРЛЭЛ**

#### **17 дугаар зүйл. Өмч**

17.1.Соёлын байгууллагын өмчтэй холбогдох харилцааг Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар зохицуулна.

17.2.Соёлын зориулалтаар ашиглаж байгаа төрийн болон орон нутгийн өмчийн барилга байгууламж, эзэмшил газрыг тухайн байгууллагын үндсэн чиг үүрэгт нь харшлах өөр зориулалтаар ашиглуулах, эзэмшүүлэхийг хориглоно.

#### **18 дүгээр зүйл. Соёлын үйл ажиллагааны санхүүжилт**

18.1.Соёлын үйл ажиллагааны санхүүжилтийн тогтолцоо нь иргэнд тэгш, хүртээмжтэй, чанартай соёлын үйлчилгээ үзүүлэхэд чиглэгдэнэ.

18.2.Соёлын үйл ажиллагааны төсөв нь улсын болон орон нутгийн төсөв, Засгийн газрын тусгай сан, дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллагын хандив, соёлын байгууллагын төлбөртэй үйлчилгээ, гадаад, дотоодод зохион байгуулагдсан соёл, урлагийн арга хэмжээнээс олсон орлого, өөрийн үйл ажиллагааны орлого, хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

18.3. Соёлын үйл ажиллагааны зардлыг улсын төсөвт бие даасан хөтөлбөр болгож батална.

18.4. Төрийн өмчит соёлын байгууллагын улсын төсвөөс санхүүжүүлэх хөрөнгийг өөрийн үйл ажиллагааны орлого болон байгууллага, иргэдийн хандивын хэмжээгээр багасгаж төлөвлөх, соёлын үйл ажиллагаанд зориулсан төсвийн хөрөнгийг өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно.

18.5. Урлагийн шилдэг бүтээлийг улсын санд худалдан авч байна. Шилдэг бүтээл шалгаруулан худалдан авах, бүтээлийг улсын санд шилжүүлэх, хамгаалах, ашиглах журмыг Засгийн газар батална.

18.6. Хүүхдэд зориулсан уран бүтээлд санхүүгийн дэмжлэг үзүүлнэ. Санхүүгийн дэмжлэг үзүүлэх журмыг Засгийн газар батална.

18.7. Олон улсын хэмжээний соёл, урлагийн наадам, уралдаан тэмцээн, үзэсгэлэн, номын яармагт оролцоход төрөөс дэмжлэг үзүүлж, онцгой амжилт гаргасан соёлын ажилтан, уран бүтээлчдэд мөнгөн шагнал олгоно. Дэмжлэг үзүүлэх, мөнгөн шагнал олгох журмыг Засгийн газар батална.

## **19 дүгээр зүйл. Соёлын ажилтны үнэлээмж, баталгаа**

19.1. Соёлын салбарын хүний нөөцийн бодлогыг Засгийн газар батална.

19.2. Соёлын ажилтан соёлын үйл ажиллагаа эрхлэн, үүсгэн байгуулагчаас тогтоосон цалин, нэмэгдэл хөлс авна.

19.3. Соёлын ажилтанд мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгоно. Мэргэшлийн зэргийн нэмэгдлийн хөрөнгийг үүсгэн байгуулагч энэ хуулийн 8.2-т заасан журмын хүрээнд өөрийн байгууллагын төсөвт тусгана.

19.4. Төрийн болон орон нутгийн өмчийн соёлын байгууллагын ажилтны нэмэгдэл хөлс, нийгмийн баталгааг Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хуулиар зохицуулна.

19.5. Энэ хуулийн 19.4-т зааснаас бусад соёлын байгууллагын ажилтны нийгмийн баталгааг үүсгэн байгуулагч хариуцна.

## **20 дугаар зүйл. Соёлын үйлдвэрлэл**

20.1. Төрөөс дэмжлэг үзүүлэх соёлын үйлдвэрлэлийн чиглэлийг Засгийн газар батална.

20.2. Төрөөс соёлын үйлдвэрлэлд дараахь дэмжлэг үзүүлнэ.

20.2.1. соёлын үйлдвэрлэлийн хөтөлбөр батлан, хэрэгжүүлэх;

20.2.2. соёлын үйлдвэрлэлд хөрөнгө оруулалт төвлөрүүлэх, дэмжлэг үзүүлэх тогтолцоог бий болгох;

20.2.3. инноваци шингэсэн бүтээгдэхүүн, үйлдвэрлэлд санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

20.2.4.соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх олон улсын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

20.2.5.соёлын арга хэмжээ, соёлын бараа, үйлчилгээг үйлдвэрлэх, түгээх, хуваарилах арга хэлбэрийг сайжруулж, хүртээмжтэй ашиглах нөхцөлийг бүрдүүлэх.

20.3.Соёлын үйлдвэрлэлийн хөтөлбөрийг Засгийн газар батална.

## **21 дүгээр зүйл.Мерчандайзийн гэрээ**

21.1.Иргэний хуулийн 338<sup>1</sup> дүгээр зүйлийн дагуу мерчандайзийн гэрээгээр өмчлөгч, түүний зөвшөөрснөөр эзэмшигч соёлын үнэт зүйлийн загвараар бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах эрхийг үйлдвэрлэгч, борлуулагчид олгох ба үйлдвэрлэгч, борлуулагч нь үйл ажиллагаа явуулж, эзэмшигчид борлуулалтын орлогоос соёлын үнэт зүйл ашигласны төлбөр төлөх үүрэг хүлээнэ.

21.2.Мерчандайз нь зохиогчийн эрх, барааны тэмдэг, бүтээгдэхүүний загварын эрхээр хамгаалагдана.

21.3.Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дараахъ загвараар бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах эрхийг олгоно:

21.3.1.төрийн өмчийн соёлын байгууллагын эзэмшиж байгаа соёлын үнэт зүйл, урлагийн бүтээл, соёлын биет өв;

21.3.2.улс, орон нутгийн музейд хадгалагдаж буй соёлын өв, үзмэр;

21.3.3.түүх, соёлын үл хөдлөх дурсгал.

21.4.Энэ хуулийн 21.3-д зааснаас бусад орон нутгийн өмчийн соёлын үнэт зүйл, урлагийн бүтээлийн загвараар бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах эрхийг тухайн шатны Засаг дарга олгоно.

21.5.Энэ хуулийн 21.3-д зааснаас бусад төрийн өмчийн байгууллагын эзэмшиж буй соёлын үнэт зүйл, урлагийн бүтээлийн загвараар бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах эрхийг тухайн салбарын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно.

21.6.Хууль, гэрээнд өөрөөр заагаагүй бол мерчандайзийн гэрээг Иргэний хуулийн дагуу бичгээр байгуулж дараахъ зүйлийг тусгана:

21.6.1.мерчандайзийн зүйлийн хэмжээ, загвар, өнгө, материалын дэлгэрэнгүй тодорхойлолт;

21.6.2.мерчандайзийн гэрээний дагуу үйлдвэрлэх, борлуулах бүтээгдэхүүний тоо хэмжээ;

21.6.3.үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг борлуулах борлуулагч, борлуулах цэгийн мэдээлэл;

21.6.4.мерчандайзийн зүйлийг үйлдвэрлэх, борлуулахад шаардлагатай санхүүжилтийн хэлбэр, нөхцөл;

21.6.5.мерчандайзийн зүйлийг гэрээнд заасны дагуу үйлдвэрлэх, борлуулах болон чанарын баталгаа;

21.6.6.загвар ашигласны төлбөрийн хэмжээ, нөхцөл;

21.6.7.мерчандайзийн гэрээний хугацааг сунгах, гэрээний эрх, үүргийг шилжүүлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах, мерчандайзийн гэрээ ба холбогдох бусад гэрээ хоорондын харилцаа, гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл, үүргээ биелүүлээгүй тохиолдол ба гэрээ цуцлах, дуусгавар болох үндэслэл, маргаан шийдвэрлэх журам;

21.6.8.тaluуд харилцан тохиролцсон бусад зүйл.

## ТАВДУГААР БҮЛЭГ

### СОЁЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААН ДАХЬ ЗӨВШӨӨРӨЛ, ХЯНАЛТ, ХЯЗГААРЛАЛТ

#### 22 дугаар зүйл. Зөвшөөрөл

22.1. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага соёлын агентын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох журмыг баталж, зөвшөөрлийг олгоно.

22.2.Соёлын агентийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүсэгч нь Зөвшөөрлийн тухай хуульд заасан баримт бичгээс гадна зөвшөөрөл хүсэгч иргэний, хуулийн этгээд бол удирдах, шийдвэр гаргах, соёлын ажилтантай шууд харилцан ажиллах иргэний хууль, эрх зүй, эдийн засаг, менежментийн талаарх мэдлэгийг нотлох баримт бичиг, эдийн засаг, хүний эрүүл мэнд, хүч хэрэглэсэн гэмт хэрэгт холбогдож байгаагүй талаарх тодорхойлолтыг өргөдөлд хавсаргана.

22.3.Соёлын агент соёлын ажилтан тус бүртэй бичгээр гэрээ байгуулна.

22.4.Соёлын агентын ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх удирдлага, менежер өөрчлөгдөхөд зөвшөөрөл олгогч байгуулагад урьдчилан мэдэгдэнэ.

22.5.Соёлын агент нь уран бүтээлчийн эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэхүйц нөхцөлд ажиллуулахаар явуулахгүй байх, зуучлан ажиллуулах газрыг урьдчилан судалсан байна.

22.6.Соёлын агент нь хүүхдийг согтууруулах ундаа борлуулах, худалдах, түүгээр үйлчлэх орчинд ажиллуулахаар явуулахыг хориглоно.

22.7.Соёлын агентын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүсэгч нь Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 22.1.14-д заасны дагуу хураамж төлнө.

#### 23 дугаар зүйл.Соёлын үйл ажиллагаанд тавих хяналт, хязгаарлалт

23.1.Соёлын үйл ажиллагаанд мэргэжлийн хяналтын байгууллага, соёлын хяналтын улсын байцаагч хяналт тавина.

23.2.Хууль тогтоомжоор хориглоогүй соёлын үйл ажиллагаа явуулахад төрийн болон бусад байгууллага, улс төрийн нам, эвсэл, холбоо, тэдгээрийн албан тушаалтан хөндлөнгөөс оролцох, дарамт шахалт үзүүлэхийг хориглоно.

23.3.Угсаатан ястны соёлыг ялгаварлан гадуурхах, хавчин хязгаарлахыг хориглоно.

23.4. Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, соёлд хор хохирол учруулах, дайн түрэмгийлэл, хүчирхийлэл, садар самууныг сурталчлах соёлын үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

23.5.Уран бүтээлчийн үүдэл санаа, ур чадварын нууцыг түүний зөвшөөрөлгүйгээр задруулахыг хориглоно.

23.6.Олон нийтийн радио, телевизийн нэвтрүүлж байгаа уран сайхан, нийтлэл, танин мэдэхүйн нэвтрүүлгийн нийт агуулгын 60 хувиас доошгүй нь, хүүхдэд зориулсан уран сайхан, нийтлэл, танин мэдэхүйн нэвтрүүлгийн 70 хувиас доошгүй нь үндэсний нэвтрүүлэг байна.

23.7.Олон нийтийн телевизээс бусад Монгол Улсад бүртгэлтэй өргөн нэвтрүүлгийн телевиз, радио, кабелийн сувгаар дамжуулж байгаа уран сайхан, нийтлэл, танин мэдэхүйн нэвтрүүлгийн нийт агуулгын 50 хувиас доошгүй нь, хүүхдэд зориулсан уран сайхан, нийтлэл, танин мэдэхүйн нэвтрүүлгийн нийт агуулгын 60 хувиас доошгүй нь үндэсний нэвтрүүлэг байна.

23.8.Театр, үзвэрийн цэгээр сар тутам түгээх кинонд үндэсний киноны эзлэх хувь, интернет протоколд сууринсан телевиз /Ай-Пи телевиз/-ийн уран сайхан, нийтлэл, танин мэдэхүйн видео санд байршсан нийт хөтөлбөрт үндэсний кино, нэвтрүүлгийн цагийн эзлэх хувь 40 хувиас доошгүй байна.

23.9.Эцэг, эх, асран хамгаалагчаас зөвшөөрөл аваагүй, холбогдох даатгал хийгээгүй тохиолдолд соёлын дотоод, гадаад үйл ажиллагаанд насанд хүрээгүй хүнийг оролцуулахыг хориглоно.

23.10. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид нь хөшөө дурсгалын цогцолбор байгуулах, соёлын байгууллага байгуулах, соёлын үнэт зүйлсийг тогтоож хамгаалалтад авах тухай шийдвэр гаргахад соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, мэргэжлийн холбоодын саналыг авна.

## **ЗУРГААДУГААР БҮЛЭГ**

### **БУСАД ЗҮЙЛ**

#### **24 дүгээр зүйл. Соёлын хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

24.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Хөдөлмөрийн хууль, Төрийн албаны тухай хууль, Зөрчлийн хуулд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

24.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдийн үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Зөрчлийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

#### **25 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

25.1.Энэ хуулийг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар  
сарын ....ны өдөр

Улаанбаатар  
хот

### ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**1996 оны 4 дүгээр сарын 11-ны өдөр баталсан Соёлын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Соёлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар  
сарын ....ны өдөр

Улаанбаатар  
Хот

### ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд дор дурдсан агуулга бүхий 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсэг нэмсүгэй:

**“15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсэг:**

15.4. Соёл урлагийг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах журмыг Засгийн газар батална.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Соёлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрднө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар  
сарын ....ны өдөр

Улаанбаатар  
Хот

### АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Ашигт малтмалын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 дахь хэсгийн “болгох,” гэсний дараа “соёл,” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Соёлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

### ГАРЫН ҮСЭГ

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар  
сарын ....ны өдөр

Улаанбаатар  
Хот

### ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.4 дахь заалтын “улсын” гэсний өмнө “үндэсний соёлын байгууллага,” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Соёлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

### ГАРЫН ҮСЭГ

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### НОМЫН САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Номын сангийн тухай хуульд дор дурдсан агуулга бүхий 10 дугаар зүйлийн 10.5, 10.6 дахь хэсэг, 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсэг тус тус нэмсүгэй:

10.5.Хүүхдийн номын сан нь хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон ном, мэдээллийн үйлчилгээг үзүүлнэ.

10.6.Бүх төрлийн номын сангийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, салбарын хөгжлийн бодлого боловсруулахад санал, дүгнэлт өгөх чиг үүрэг бүхий орон тооны бус Номын сангийн Үндэсний зөвлөл соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын дэргэд ажиллана. Зөвлөлийн ажиллах журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

24.5.Энэ хуулийн 24.1-д заасан зардлыг төр хариуцна.

**2 дугаар зүйл.** Номын сангийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “сургалтын,” гэсний дараа “хүүхдийн,” гэж, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн “авчрах” гэсний дараа “, монгол судлалын чиглэлээр гадаадад хэвлэгдсэн ном, хэвлэлийн бүтээгдэхүүнийг Үндэсний номын сангийн сан хөмрөгт нөхөн бүрдүүлэх” нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Номын сангийн тухай хуулийн хэсгийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийг Соёлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Газрын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.15 дахь заалтыг нэмсүгэй:

16.1.15.хамгаалалтын бүс тогтоосон түүх, соёлын дурсгалт газар.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Соёлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

### ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ГАЗРЫН ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Газрын төлбөрийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/ хамгаалалтын бүс тогтоосон түүх, соёлын дурсгалт газар, өмчийн хэлбэр харгалзахгүйгээр бүх төрлийн соёлын байгууллагыг болон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг байгаль, түүх, соёлын дурсгалт зүйлс, түүх, соёлын дурсгалыг хадгалах, хамгаалахад зориулан эзэмшиж, ашиглаж байгаа газрынх нь;.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Соёлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Хүүхэд хамгааллын тухай хуулийн Хоёрдугаар бүлэгт 9<sup>1</sup> дүгээр зүйл нэмсүгэй.

#### **9<sup>1</sup> дугаар зүйл. Соёл, спортын үйл ажиллагаан дахь хүүхэд хамгаалал**

9<sup>1</sup>.1.Хүүхдийг соёлын үйл ажиллагаа, урлагийн тоглолт, спортын тэмцээн, бусад арга хэмжээнд эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн бичгэн зөвшөөрлийн үндсэн дээр, түүний хөгжил, эрүүл мэнд, хүмүүжил, төлөвшилд, сөрөг нөлөө үзүүлэхүйгүй орчинд оролцуулна.

9<sup>1</sup>.2. Соёл, спортын үйл ажиллагаа, урлагийн тоглолт, спортын тэмцээн, бусад арга хэмжээнд оролцуулахдаа хичээл сургалтын үйл ажиллагааг тасалдуулахгүй байх, хоцрогдлыг арилгах арга хэмжээг авна.

9<sup>1</sup>.3. Хичээл сургалтын үйл ажиллагааг тасалдуулахгүй байх, хоцрогдлыг арилгах арга хэмжээг эцэг, эх, асран хамгаалагч, арга хэмжээнд оролцуулсан этгээд хамтран, сургалтын хөтөлбөр, агуулгын хүрээнд болон төрийн захиргааны байгууллагаас улс, бүс, орон нутгийн хэмжээнд зохион байгуулгадаж байгаа арга хэмжээнд оролцсон бол сургуулийн удирдлага тус тус зохион байгуулна.

9<sup>1</sup>.4-д “Соёл, спорт, олон нийтийн үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг хамгаалах журмыг соёлын болон хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага баталж, мөрдүүлнэ”

**2 дугаар зүйл.** Хүүхэд хамгааллын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2 дахь хэсгийн “тоглоом” гэсний дараа “ном, урлагийн бүтээл” гэж, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “үйлчилгээ,” гэсний дараа “соёлын үйл ажиллагаа, урлагийн тоглолт, арга хэмжээ,” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Соёлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрднө.

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ГЭР БҮЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Гэр бүлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсгийн “батална.” гэсний дараа “Угийн бичиг хөтлөх журмыг нь соёлын өв, хүн ам, архивын бодлого, үйл ажиллагаатай уялдуулсан байна.” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Соёлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс өхлэн дагаж мөрдөнө.

### ГАРЫН ҮСЭГ

**Төсөл**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

**2019 оны...дугаар  
сарын....-ны өдөр**

**Улаанбаатар  
хот**

**УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ  
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 5.1.46 дахь заалт, 22 дугаар зүйлийн 22.1.4 дахь заалт тус тус нэмсүгэй.

5.1.46. Соёлын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу зөвшөөрөл олгох.

22.1.14. Соёлын агентын үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрөл олгоход 400000-600000 төгрөг

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Соёлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**ГАРЫН ҮСЭГ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
Хот

### ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Зөрчлийн тухай хуулийн 9 дүгээр бүлгийн 9.6 дахь зүйлийг дор дурдсанаар өөрчилсүгэй.

#### 9.6 дугаар зүйл. Соёлын тухай хууль зөрчих

1. Соёлын зориулалтаар ашиглаж байгаа төрийн болон орон нутгийн өмчийн барилга байгууламж, эзэмшил газрыг тухайн байгууллагын үндсэн чиг үүрэгт нь харшлах өөр зориулалтаар ашигласан, эсхүл эзэмшсэн бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг хорин таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2. Музей, орон нутгийн номын сан, орон нутаг судлах танхимын мэдээллийн үйлчилгээ үйлчилгээнд 16 хүртэлх насны хүүхэд үнэ төлбөргүй хамруулах журам зөрчсөн хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг хорин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3. Соёлын агентын үйл ажиллагааг зөвшөөрөлгүйгээр эрхэлсэн бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4. Уран сайхан, нийтлэл, танин мэдэхүйн нэвтрүүлгийн нийт агуулгад эзлэх үндэсний болон хүүхдэд зориулсан нэвтрүүлэг, киноны эзлэх хувийг баримтлаагүй бол хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5. Эцэг, эх, асран хамгаалагчаас зөвшөөрөл аваагүй, даатгалд хамруулалгүйгээр соёлын дотоод, гадаад үйл ажиллагаанд насанд хүрээгүй хүнийг оролцуулсан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Соёлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс өхлэн дагаж мөрдөнө.

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны...дугаар  
сарын....-ны өдөр

Улаанбаатар  
хот

### СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Соёлын өвийг хамгаалах тухай хуульд дор дурдсан агуулгатай дараахь хэсэг, заалт нэмсүгэй.

#### 1/8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсэг:

“8.6.Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг улсын хамгаалалтын зэрэглэлд нэр дэвшүүлэх, хянан шийдвэрлэх журам, түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг хосгүй үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлд нэр дэвшүүлэх, хянан шийдвэрлэх журам, соёлын биет бус өвийг төлөөллийн болон яаралтай хамгаалах шаардлагатай үндэсний жагсаалтад бүртгэх журмыг Засгийн газар батална.”

#### 2/8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсэг:

“8.7.Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг аймаг, нийслэлийн хамгаалалтын зэрэглэлд нэр дэвшүүлэх, хянан шийдвэрлэх журам, түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлд нэр дэвшүүлэх, хянан шийдвэрлэх журмыг Соёлын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн батална.”

#### 3/8 дугаар зүйлийн 8.8 дахь хэсэг:

“8.8.Энэ хуулийн 8.1, 8.2-т заасан зэрэглэлийг шатлан дэвшүүлэх зарчмаар тогтоох бөгөөд давхардуулж тогтоохгүй.”

#### 4/13 дугаар зүйлийн 13<sup>1</sup>.1.8 дахь заалт:

“13<sup>1</sup>.1.8.соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн соёлын биет бус өвийн төлөөллийн болон яаралтай хамгаалах шаардлагатай үндэсний жагсаалт болон соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн үндэсний жагсаалтыг тус тус батлах;”

#### 5/45 дугаар зүйлийн 45.5 дахь хэсэг:

“45.5.Хамгаалалтын бүсэд байгаа үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалтын байдлыг сайжруулах зорилгоор түүний эх төрх, бүрэн бүтэн байдалд нь

хохирол учруулахгүй байх хэлбэрээр шинээр барилга, байгууламж барьж, судалгаа сурталчилгааны зориулалтаар ашиглаж болно.”

#### **6/52<sup>1</sup> дүгээр зүйлийн 52<sup>1.3</sup> дахь хэсэг:**

“52<sup>1.3</sup>. Соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хувийн өмчид байгаа түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрлийг дурсгалт зүйлийг өмчлөгч эсхүл өмчлөгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчид олгоно.” Улсын хилээр нэвтрүүлэх түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл нь энэ хуулийн 20.7, 32.2.2-т заасан бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлсэн байвал зохино.”

**2 дугаар зүйл.** Соёлын өвийг хамгаалах тухай тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалтын “илэрхийлэгдэх” гэсний дараа “дангаар болон цогцолбор байдлаар орших” гэж, 6 дугаар зүйлийн 6.1.17 дахь заалтын “соёлын” гэсний дараа “хөдлөх” гэж, 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “холбогдох” гэсний дараа “бусад” гэж, 9 дүгээр зүйлийн гарчиг хэсгийн “Соёлын” гэсний дараа “биет” гэж, 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн “түүх, соёлын” гэсний дараа “хөдлөх” гэж, 33 дугаар зүйлийн 33.2.2 дахь заалтын дугаарын цэгийн ард /“соёлын” гэсний өмнө/ “харьяалах аймаг, нийслэлийн” гэж, 45 дугаар зүйлийн 45.3.3 дахь заалтын дугаарын цэгийн ард /”гэр” гэсний өмнө/ “энэ хуулийн 45.5-д зааснаас бусад зорилгоор” гэж, 52 дугаар зүйлийн гарчиг хэсгийн “соёлын” гэсний дараа “хөдлөх” гэж, 58 дугаар зүйлийн 58.3 дахь хэсгийн “хамгаалалтад” гэсний дараа “соёлын болон” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтын “чулуужсан” гэснийг, 52 дугаар зүйлийн 52.1 дэх хэсгийн “эх олдворыг” гэснийг тус тус хассугай.

**4 дүгээр зүйл.** Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн дараах хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

#### **1/8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг:**

8.1. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын эх төрх байдал, бүрэн бүтэн байдал, түүх, соёл, шинжлэх ухааны үнэ цэнэ, ач холбогдлыг харгалзан улс, аймаг, нийслэл, сум дүүргийн хамгаалалтын зэрэглэл тогтооно.”

#### **2/8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг:**

“8.2. Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн эх төрх байдал, бүрэн бүтэн байдал, түүх, соёл, шинжлэх ухааны үнэ цэнэ, ач холбогдлыг харгалзан үнэт, хосгүй үнэт зэрэглэл тогтооно.”

#### **3/8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэг:**

“8.4. Соёлын биет бус өвийн түүх, соёл, урлаг, гоо зүйн болон шинжлэх ухааны үнэ цэнэ, ач холбогдлыг харгалзан соёлын биет бус өвийн төлөөллийн

үндэсний жагсаалт болон яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний жагсаалтад бүртгэнэ.”

**4/9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг:**

“9.1. Нийтийн өмчийн соёлын биет өвд үнэлгээ тогтоох журмыг санхүү, төсвийн болон соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

**5/9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг:**

“9.3.Өмчлөгчийн хүсэлтээр хувийн өмчийн соёлын биет өвд энэ хуулийн 9.1-т заасан журмын дагуу үнэлгээ тогтоож болно.”

**6/12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалт:**

“12.1.1.төрөөс соёлын өвийг хамгаалах талаар баримтлах бодлогыг тодорхойлох;”

**7/13 дугаар зүйлийн 13.1.7 дахь заалт:**

“13.1.7.улсын хамгаалалтын зэрэглэлд байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтыг батлах;”

**8/13 дугаар зүйлийн 13.1.8 дахь заалт:**

“13.1.8.түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалтыг батлах;”

**9/13 дугаар зүйлийн 13.1.12 дахь заалт:**

“13.1.12.түүх, соёлын үл хөдлөх дурсгал болон дурсгалт газарт хамгаалалтын бус тогтоох, өөрчлөх, цуцлах;”

**10/14 дүгээр зүйлийн 14.1.5 дахь заалт:**

“14.1.5.аймаг, нийслэлийн хамгаалалтын зэрэглэлд байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтыг батлах;”

**11/14 дүгээр зүйлийн 14.1.11 дэх заалт:**

“14.1.11.түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг хилээр нэвтрүүлэх, палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгаа хийх зөвшөөрөл олгох;”

**12/14 дүгээр зүйлийн 14.1.12 дахь заалт:**

“14.1.12.соёлын биет бус өвийн, түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн, палеонтологи археологийн болон сэргээн засварлах мэргэжлийн зөвлөлийн ажиллах журмыг батлах;

**13/15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэг:**

“15.2.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал сум дүүргийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтыг батална.

**14/20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсэг:**

“20.3.Соёлын өвийн үндэсний төв нь соёлын өвийг бүртгэх, судлах, хадгалах, сэргээн засварлах, авран хамгаалах, сурталчлах чиг үүрэг бүхий соёл, эрдэм шинжилгээний байгууллага байна.”

**15/27 дугаар зүйлийн 27.3 дахь хэсэг:**

“27.3.Монгол Улсын нутаг дэвсгэрт палеонтологи, археологийн хайгуул, малтлага хийх болон соёлын биет бус өвийн судалгаа хийх зөвшөөрлийг соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх харьяалах Мэргэжлийн зөвлөлийн саналыг үндэслэн соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно.”

**16/30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэг:**

“30.2.Олдворыг эзэмшүүлэх, түр хадгалах зорилгоор музей, эрдэм шинжилгээний байгууллага бусад байгууллагад шилжүүлэх асуудлыг соёлын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн олдворыг анх илрүүлсэн эрдэм шинжилгээний байгууллага, судлаачын саналыг харгалзан шийдвэрлэнэ.”

**17/50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсэг:**

“50.1.Төрийн болон орон нутгийн өмчийн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлээр гадаадад үзэсгэлэн гаргах ажлыг соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосон байгууллага зохион байгуулна. Энэ заалт хувь хүн, хуулийн этгээд хувийн өмчийн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлээр гадаадад үзэсгэлэн гаргахад хамаarahгүй.”

**18/52 дугаар зүйлийн 52.3 дахь хэсэг:**

“52.3.Соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 52.1-д зааснаас бусад нийтийн өмчийн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг дараахь зорилгоор эргүүлэн авчрах нөхцөлтэйгөөр улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл олгоно.”

**19/52 дугаар зүйлийн 52.8 дахь хэсэг:**

“52.8. Соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага шүүхийн шийдвэрээр болон бусад хууль ёсны шийдвэрээр төрийн өмчлөлд шилжүүлсэн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг холбогдох журмын дагуу музей, эрдэм шинжилгээний байгууллагад шилжүүлнэ.”

**5 дугаар зүйл.** Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5 дахь хэсгийн “Соёлын өвийн судалгаа” гэснийг “Палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгаа” гэж, 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсгийн “анхны төрх байдал” гэснийг “эх төрх, бүрэн бүтэн байдал” гэж тус тус өөрчилсүгэй.

**6 дугаар зүйл.** Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 8.3, 8.5 дахь хэсэг (бүхэлд нь), 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг, 14<sup>1</sup> дүгээр зүйлийн 14<sup>1</sup>.1.4, 14<sup>1</sup>.1.9 дэх заалт, 27 дугаар зүйлийн 27.6 дахь хэсэг, 40 дүгээр зүйлийн 40.4 дэх хэсэг, 46 дугаар зүйлийн 46.6 дахь хэсэг, 52 дугаар зүйлийн 52.3.4 дэх заалт, 54, 55, 56, 57 дугаар зүйл, 58 дугаар зүйлийн 58.4 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

## ГАРЫН ҮСЭГ